

МОНГОЛ УЛС, БНХАУ-ЫН ХООРОНД УЛС ХООРОНДЫН БАЙНГЫН АЧАА  
ТЭЭВЭРЛЭЛТ ГҮЙЦЭТГЭХ ЭРХ АВАХАД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	
1	Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэхэд тавигдах шаардлагуудыг хангасан тухай нэгдсэн танилцуулга
2	Хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ, нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, удирдах ажилтны анкет
3	Тээвэрлэлтийн маршрут, чиглэлийг тодорхойлсон зураг, түүнийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэрийн хуулбар
4	Ачаа илгээгч эсхүл хүлээн авагчтай байгуулсан тээвэрлэлтийн гэрээ
5	Тээвэрлэлтийн чиглэлийн дагуух өөрийн мэдлийн хатуу хучилттай авто замтай бол түүний засвар арчлалтын төлөвлөгөө /Авто зам ашиглах гэрээ/
6	Тээвэрлэлт гүйцэтгэх автотээврийн хэрэгслийн жагсаалт, тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар
7	Жолоочийн болон мэргэшсэн жолоочийн үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
8	Автотээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах инженер техникийн ажилтны анкет
9	Автотээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлыг хангах зориулалтын засвар, үйлчилгээний байгууламж, тээвэрлэлтийг гүйцэтгэх жолооч, бусад ажилчдыг байршуулах зориулалт бүхий өөрийн эсхүл түрээсийн байртай эсэх талаарх танилцуулга /холбогдох баримт/
10	Тээвэрлэлтээс хүрээлэн байгаа орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх талаарх арга хэмжээний төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулсан баримт
11	Шаардлагатай бол тээвэрлэлт гүйцэтгэхэд гадаадаас авах ажиллах хүчний тоо, эрх бүхий байгууллагаас олгосон хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
12	Тээврийн хэрэгсэл бүр дээр улс хоорондын ачаа тээвэрлэлтэд тавих нэмэлт шаардлага хангаж буй тухай АТХУБайцаагийн дүгнэлт гаргуулсан байх

Жич: Тээвэрлэгч нь дээрх материалуудыг бүрдүүлэн “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т албан хүсэлтийн хамт хүргүүлж дүгнэлт гаргуулна.

-oOo-